



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/176

Өмнөдэлгэр сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/471 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2024 онд шинээр гарсан сумын хэмжээний мэдрэмтгий бүх төл малыг хамруулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ноос эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.
2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцины хуваарь, дархлаажуулалтад хамрагдах төлийн тоог хавсралтаар баталсугай.
3. Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа, хоолой, ажиллах хүн хүчний бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Товлосон хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, холбогдох байгууллагад мэдэгдэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Э.Ариунзаяа)-д үүрэг болгосугай.
5. Дархлаажуулалтын ажлын хэсгийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, санхүүгийн болон бусад баримт материалыг бүрдүүлэн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг мал эмнэлгийн тасагт хариуцуулсугай.



Б.ЭРДЭНЭБААТАР

D:disk/bichig hereg/ zahiramj

2024100370



2024 ОНД БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	МЭҮНэгж	Малын тоо /толгой/				Шаардлагатай вакцин				Вакцины шингэлэгч /литр/			
		Хурга	Ишиг	Нийт	Нийт тун	Хайрцаг	Задгай /ширхэгээр/	Литр	Хайрцаг	Шил /пакет/			
1	Юмт гэгээ	36868	29145	66013	66013	33		66	8	10			
2		Өвөр зотлог	6003	4422	10425	10425	5	4	10.4	1	12		
3	Хэйлти анимал стронг	13600	8398	21998	21998	11		22	2	30			
4		Хичээнгүй экспресс	16400	11164	27564	27564	13	16	27.6	3	18		
5	Мэргэн жонон	16800	9200	26000	26000	13		26	3	10			
		ДҮН	89671	62329	152000	152000	75	20	152	17	80		